



## СҮХБААТАР АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

**Аудит хийх үндэслэл:** Монгол Улсын Ерөнхий аудитораас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийг үндэслэн гүйцэтгэв

### **АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

Аймгийн ОНХС-ийн төлөвлөлтийг хууль тогтоомжийн дагуу боловсруулсан боловч ихэнх сумд ОНХС-г төлөвлөөгүй, орлогын шилжүүлгийг хуульд заасан харьцаагаар хуваарилаагүй, ИНХ-аар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.



### **Аудитын нэр:**

**Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт**

**Баруун-Урт сум  
2016 он**

## АГУУЛГА

### Аудитын тайланг бэлтгэсэн:

#### ААГ-ын аудитын хэлтэс

Сүхбаатар аймгийн  
аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор

М.Нарантуяа

Аудитын менежер

Г.Даваа

2016 оны 4 дүгээр сарын  
29-ны өдөр

Уг тайланг ААГ-ын Веб  
сайт-аас

үзнэ үү. [http://sb-  
audit.webs.com/](http://sb-audit.webs.com/)

Аудитын тайлан,  
дүгнэлттэй холбоотой  
асуудлаар нэмж  
тодруулах, асууж лавлах  
зүйл байвал багийн утас  
70512123, 70512127

Газрын дарга, тэргүүлэх  
аудитор 70518396  
дугаарын факсаар  
харилцана уу

#### ХАЯГ:

Аймгийн аудитын газар  
Баруун-Урт сум 7-р баг  
төрийн захиргааны байр  
өрөө №226 тоот

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй,  
шалгуур үзүүлэлт  
Товчилсон үгийн тайлбар

4-5  
6

**Дэд зорилт-1.1.** Аймгийн ОНХС-гийн орлогын төлөвлөлтийг хууль тогтоомжийн дагуу хийсэн боловч ихэнх сум ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

7-8

**Дэд зорилт-1.2.** ОНХС-аас хуваарилагдсан орлогын шилжүүлгийг хууль, журамд заасан харьцааг баримтлалгүй аймгийн ОНХС-аас сумдад 16.7 хувиар дутуу хуваарилсан байна.

8-9

**Дэд зорилт-1.3.** Аймаг 2015 онд хийгдэх хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг гаргаж иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлэг явуулаагүй байна

9

**Дэд зорилт-1.4:** ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртөг, ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулалгүй төлөвлөж, баталсан байна.

9

**Дэд зорилт-1.5:** Дарьганга, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Баяндэлгэр сум ИНХ-аар дэмжигдээгүй 7 төсөл арга хэмжээг 62460.0 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

10-11

Дэд зорилт-2.1: Аймгийн ОНХС-гийн орлогыг хууль тогтоомжид заасан нэр төрлөөр бүрдүүлж байгаа боловч зарим сумд ОНХС-гийн эх үүсвэрийг бүрдүүлэх талаар хангалттай ажиллаагүй байна.....11-12

Дэд зорилт-2.2: ОНХС-гийн хөрөнгийн 63.4 хувийг өмнөх оны ажлын дутуу гүйцэтгэл, он дамжин хэрэгжиж буй ТАХ-нд зарцуулсан байна.....12-16

Дэд зорилт-2.3: Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг комисс ажлын гүйцэтгэлээр хүлээн аваагүйгээс 43157.5 мянган төгрөгийн ажил дутуу хийгдсэн байна.....16

Дэд зорилт-3.1: ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд ИТХ-аас холбогдох заавар, журмын дагуу хяналт хийгдээгүй байна..... 16

Дэд зорилт-3.2 Аймгийн бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг иргэдэд хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлсэн байна..... 17

Дэд зорилт-3.3 Өмнөх оны аудитаар өгсөн акт 86.2%, албан шаардлага 98.8%, зөвлөмж 81.8%-тай хэрэгжсэн байна.....18-19

ДҮГНЭЛТ:..... 19

ЗӨВЛӨМЖ:..... 20

САНАЛ, ӨГСӨН ТАЙЛБАР:..... 21

Сүхбаатар аймаг

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

### Аудит хийх үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2016 оны “Аудитын сэдэв батлах” тухай 01 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт УАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийг үндэслэн гүйцэтгэв.

### Аудитын зорилт

2015 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэхэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын дүнг УИХ-д танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу төлөвлөж хуваарилсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын бүрдүүлж, зарцуулсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх.

### Аудит хамарсан хүрээ

Аудитаар аймаг, сумын ИТХ, ЗДТГ, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд шалгарсан ААНБ-ууд болон 2015 онд улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаар тэдний гүйцэтгэсэн ажлын тайлан болон санхүү, үйл ажиллагааны баримт материалыг хамруулан шалгав.

Тус аудитаар ОНХС-ийн үйл ажиллагааны тайлан, мэдээ, санхүүгийн баримт материал, судалгаа, эрх зүйн баримт бичгүүд болон бусад баримт материалуудыг хянан шалгаж, нэгтгэн дүгнэсэн бөгөөд 2016 оны 3-р сарын 15-наас 2016 оны 5-р сарын 1-ны хооронд хийж гүйцэтгэв.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараах арга зүйг ашиглав. Үүнд:

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Засгийн газрын 2011 оны 134, 2012 оны 30 дугаар тогтоолууд, Сангийн сайдын 2012 оны 244, 2014 оны 43 дугаар тушаалууд, аймаг сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

### **Аудитад учирсан зарим бэрхшээл**

Тус аудит нь цаг хугацааны хувьд Санхүүгийн тайлангийн аудит, бусад нийцлийн болон гүйцэтгэлийн аудитадтай давхцсан, төсөв санхүүгийн боломжоос хөдөө орон нутагт ажиллахад хүндрэл гарсан.

### **Ерөнхий мэдээлэл**

Аймгийн ОНХС-гийн орлогын эх үүсвэрийг ОНХНС-гаас 7744911.4 мянга, нийт орлого, суурь орлогын зөрүүгээс 233600.0 мянга, орон нутгийн төсвөөс 649116.0 мянга, хандив тусламжаар 1842000.0 мянга нийт 10469627.4 мянган төгрөгөөр төлөвлөж, аймгийн ИТХ-аар батлуулсан байна. Аймгийн ИТХ-ын 2015 оны 3 дугаар тогтоолоор төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж ОНХНС-гаас хувиарлагдсах орлогын шилжүүлгийг 4856448.0 мянга, орон нутгийн төсвөөс 1711960.8 мянга, суурь орлого зарлагын зөрүүгээс 233600.0 мянга, хандив тусламжаар 1842000.0 мянга нийт 8644008.8 мянган төгрөгөөр тодотгожээ.

ОНХНС-аас аймгийн ОНХС-д 4856448.0 мянган төгрөг хуваарилахаас гүйцэтгэлээр 4012458.2 мянган төгрөгийн орлогын шилжүүлгийг хуваариласан байна. Батлагдсан төсвийн 58.3 хувийг сумдын ОНХС-д хуваарилахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 43.3 хувийг буюу 1737032.8 мянган төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилсан байна

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БУА	Барилга, угсралтын ажил
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ТӨӨЗ	Тендерт оролцогчид өгөх зааварчлага
ТШӨХ	Тендер шалгаруулах өгөгдлийн хүснэгт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуучлалын газар

Дэд зорилт-1 ОНХС-ийн орлогыг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөж, хуваарилаж байна уу

1

## БҮЛЭГ 1

Аймгийн ОНХС-ийн төлөвлөлтийг хууль тогтоомжийн дагуу боловсруулсан боловч ихэнх сумд ОНХС-г төлөвлөөгүй, орлогын шилжүүлгийг хуульд заасан харьцаагаар хуваарилаагүй, ИНХ-аар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

### 1.1 Аймгийн ОНХС-гийн орлогын төлөвлөлтийг хууль тогтоомжийн дагуу хийсэн боловч ихэнх сум ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймгийн ОНХС-д 4646.9 сая төгрөгийг орлогын шилжүүлэгээр хуваарилахаар төлөвлөсөн байна. Орлогын шилжүүлгийн төлөвлөлтийг хүчин зүйлээс нь хамааруулан дараах байдлаар төлөвлөсөн байна. Тухайлбал: хүн амын тооноос хамаарч 1548.9 сая, хүн амын нягтрал, Алслалт, нутаг дэвсгэрээс хамаарч 1548.9 сая, орон нутгийн татварын идэвх санаачлагаас хамаарч 1548.9 сая төгрөг олгохоор тооцжээ. Тооцооллыг хүснэгтээр харуулвал.

/ мян.төг /

Сумдын нэр	Хүн амын тоо	Хүн амын тооноос хамааруулан олгох дүн	Хүн амын нягтрал, алслалт, нутаг, дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан олгох дүн	Татварын идэвхи санаачлагаас хамааруулан олгох дүн	Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалтын дүн
Асгат	1734	47667.8	142459.9	110243	300370.7
Баяндэлгэр	4597	126371.8	128948.7	111098	366418.5
Баруун-Урт	18228	501088.8	396.6	97726.2	599211.6
Дарьганга	2852	78401.6	120439.9	107924	306765.5
Мөнххаан	4295	118069.8	115328.7	111337	344735.5
Наран	1537	42252.2	139131.7	115346	296729.9
Онгон	3650	100338.7	129727.8	109013	339079.5
Сүхбаатар	3145	86456.2	176237.7	122127	384820.9
Түвшинширээ	3074	84504.4	101365.4	115924	301793.8
Түмэнцогт	2342	64381.7	78942.4	206438	349762.1
Уулбаян	2772	76202.4	93101.6	115832	285136.0
Халзан	1595	43846.6	92224.5	113231	249302.1
Эрдэнэцагаан	6526	179400.1	230677.3	112763	522840.4
<b>Нийт</b>	<b>56347</b>	<b>1548982.1</b>	<b>1548982</b>	<b>1549002</b>	<b>4646966.5</b>

Аймгийн ОНХС-д орлогын шилжүүлэгээр 7744.9 сая төгрөг, суурь орлого зарлагын зөрүүгээс 233.6 сая, үндсэн тэнцлийн ашгаас 649.1 сая, хандив тусламжаар 1842.0 сая нийт 10469.6 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан байна.

Харин төсвийн тодотгол хийгдэж орлогын шилжүүлгийг 4856.4 сая , суурь тэнцлийн зөрүүгээс 233.6 сая, үндсэн тэнцлийн ашигаас 1711.9 сая, хандив тусламжаар төвлөрөх орлогыг 1842.0 сая нийт 8644.0 сая төгрөгөөр буюу 17.4 хувиар бууруулан баталжээ. Өөрсдийн нөөц бололцоог судлан, орлогын эх үүсвэрийг дайчлах зэрэг идэвхи санаачлагатай ажилласан зарим сумдын төлөвлөтийг дурдвал:

- **Баруун-Урт сум ОНХС-гийн** Эх үүсвэрийг аймгаас олгох орлогын шилжүүлгийг 599.2 сая, эргэн төлөгдөх эх үүсвэрээс 200.0 сая нийт 799.2 сая төгрөгөөр төлөвлөж, тодотгосон төлөвлөгөөр орлогын шилжүүлгээр 414.5 мянга, үндсэн тэнцлийн ашгаас 15.0 сая, бусад эх үүсвэрийн орлогоор 9,0 сая төгрөг төлөвлөсөн байна.
- **Халзан сум** ОНХС-гийн эх үүсвэрт орлогын шилжүүлэгээс 249.3 сая, жишиг хорооллын хашаанаас 21.0 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.
- **Түмэнцогт сум** ОНХС-гийн эх үүсвэрт орлогын шилжүүлэгийг 349.7 сая, хашааны орлогоос 3.8 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн байна.

Сумд ОНХС-гийн орлогын эх үүсвэрийг төлөвлөхдөө Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалын хавсралт “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.2<sup>1</sup>-т заасны дагуу сумын үндсэн тэнцлийн ашгаас хөрөнгө хувиарлах, татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар хөрөнгө бүрдүүлэх, зарлагын бодит хэмнэлтээс хөрөнгө хуваарилахаар тооцоолох, хандив тусламжаар хөрөнгө төвлөрүүлэх зэрэг нэр төрөл тус бүрээр ОНХС-г төлөвлөөгүй байна.

## **1.2 ОНХНС-аас хуваарилагдсан орлогын шилжүүлгийг хууль, журамд заасан харьцааг баримтлалгүй аймгийн ОНХС-аас сумдад 16.7 хувиар дутуу хуваарилсан байна.**

ОНХНС-аас орлогын шилжүүлгээр аймгийн ОНХС-д 4856.4 сая төгрөг хуваарилахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4012.5 сая төгрөг хуваарилж, 843.9 сая төгрөгийн санхүүжилт хийгдээгүй байна.

ОНХНС-гийн орлогын шилжүүлэгийн 58.3 %-ийг сумдын ОНХС-д хуваарилахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 43.3% буюу 1737032.8 мянган төгрөгийг хуваарилж “Төсвийн тухай” хуулийн 59.2<sup>2</sup> дах заалтыг зөрчжээ. Сумдад хуваарилсан санхүүжилтийг батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй нь харьцуулан авч үзвэл:

<sup>1</sup> Сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар тооцож төлөвлөнө

<sup>2</sup> Аймаг, нийслэл нь ОНХНС-аас олгосон шилжүүлэгийн 60-аас доошгүй хувийг сум, дүүргийн хөгжлийн санд ..... хуваарилна.



№	Сумдын нэр	сая төгрөг			
		Батлагдсан дүн	Гүйцэтгэлийн дүн	ОНХС-а санхүүжилт Зөрүү	Хууль, тогоомжид заасан харьцаанаас дутуу ирсэн санхүүжилтийн хувь хэмжээ.
1	Асгат	187.7	122.7	65.0	35
2	Баруун - Урт	414.6	247.1	167.5	40
3	Баяндэлгэр	229.1	143.1	86.0	37,5
4	Дарьганга	191.8	119.8	72.0	63%
5	Мөнххаан	215.5	130.5	85.0	60.6%
6	Онгон	211.9	150.9	61.0	71%
7	Наран	185.5	120.5	65.0	65%
8	Түвшинширээ	228.7	138.7	90.0	61%
9	Түмэнцогт	218.6	71.3	147.3	33%
10	Сүхбаатар	240.5	115.5	125.0	48%
11	Уулбаян	178.2	115.2	63.0	65%
12	Халзан	205.9	155.9	50.0	76%
13	Эрдэнэцагаан	126.8	105.8	21.0	83.4%
	<b>дүн</b>	<b>2834.8</b>	<b>1737.0</b>	<b>1097.8</b>	

Эндээс авч үзвэл сумдад хуваарилах ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 21.0-167.5 сая төгрөг буюу 16.6-67 хувийн хэлбэлзэлтэйгээр дутуу санхүүжүүлсэн байна. Санхүүжилтийг дутуу олгосон нь ОНХС-аас 843.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг дутуу хуваарилсан нь нөлөөлж байна.

### 1.3 Аймаг 2015 онд хийгдэх хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлын жагсаалтыг гаргаж иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлэг явуулаагүй байна.

УИХ-ын 2012 оны 60 дугаар тогтоол, ЗГ-ын 2013 оны 2 сарын 2-ны хуралдааны 7 дугаар тэмдэглэлийн дагуу аймгийн засаг даргын 2013 оны А/78 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг ЭЗХЯ, ҮХААЯ, БХБЯ, ХЯ-наас томилогдсон ажлын хэсэгтэй хамтарч 2013-2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтыг гаргаж 2548 иргэнээс санал авч эрэмбэлэн аймгийн ИТХ-ын 2013 оны 6 дугаар тогтоолоор 11 чиглэлийн 113 хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ. 2013-2016 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтаас 2015 онд хэрэгжих төсөл арга хэмжээг иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлэг явуулж тэргүүлэх ач холбогдолоор нь эрэмбэлж батлуулаагүй нь Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын” 6.2<sup>3</sup>, 6.3<sup>4</sup>, 6.4<sup>5</sup>

<sup>3</sup>.Аймаг, нийслэлийн засаг дарга тухайн шатны ОНХС-ын хөрөнгөөр дараа жил хэрэгжүүлэх ХО-т ХТАХ-ний төлөвлөгөөний урьчилсан жагсаалтыг тухайн аймаг нийслэлийн хөгжлийн бодлого чиглэл ЗД-ын мөрийн хөтөлбөрт тусгасан үйл ажиллагаа , урьд онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ХО-т, ТАХ-г харгалзан боловсруулна.

<sup>4</sup> Дээрхи жагсаалтанд сум дүүргийн иргэдийн саналыг авсан аймаг, нийслэлийн чиг үүрэгт хамаарах саналын жагсаалтыг мөн оруулна

дэх заалтуудыг зөрчсөн байна. Сумдуудад ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний саналыг баг тус бүр дээр зохион байгуулж багийн ИНХ-ын тогтоол гарсан саналыг ЗДТГ-ын ажлын хэсэг нэгтгэн ИТХ-аар батлуулж байна. Сумдын удирдлага болон багийн засаг дарга, ИНХ-ын дарга нар ОНХС-г хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль тогтоомж, тогтоол, журмыг малчид иргэдэд ухуулах, танилцуулах, сурталчлах ажил хангалтгүй байгаагаас иргэд санал асуулгад ач холбогдох өгөхгүй байх, олон ажилчидтай албан байгууллага өөрсдийн эрх ашигт нийцүүлэн санал өгч тухайн ажлыг дээгүүрт эрэмблэх зэрэг эрх зүйн акттай зөрчилдөж байгаа үр дагаварууд гарч байна.

#### 1.4 ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнүүдийн төсөвт өртөг, ТЭЗҮ, зураг төсвийг боловсруулалгүй төлөвлөж, баталсан байна.

Сумдын ИТХ нь зураг төсөв, ТЭЗҮ боловсруулаагүй, ТАХ-ний төсөвт өртгийг урьдчилан тооцоололгүй баталдаг зөрчил дутагдал давтагдаж байна. Иргэдийн саналаар дэмжигдсэн ТАХ-ний зураг төсөв, ТЭЗҮ-ийг боловсруулах төсөв хөрөнгө дутагдалтай, сум орон нутагт зураг төсөв гаргах мэргэжлийн боловсон хүчин байхгүйгээс ижил төстэй ажлын гүйцэтгэлд тулгуурлан төсөвт өртгийг урьдчилан тооцож батлуулж байгаа нь Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалын хавсралт “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3<sup>6</sup>-ыг зөрчиж байна. Мөн ОНХС-г ТЭЗҮ, зураг төсөв нь боловсрогдоогүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээнд төлөвлөж байна. Харин аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл арга хэмжээ болох авто зам, барилга, их засварын зураг төсвийг боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулжээ. Тайлант онд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл хөтөлбөрийг баталсан байдлыг харуулвал:

Сумын нэр	Шинээр хийгдэх БУА болон их засвар, тоног төхөөрөмж суурилуулах ажил		ТЭЗҮ, зураг төсөв нь батлаг-даагүй		Зураг төсөв батлагдсан ажил	
	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/	тоо	дүн /сая.төг/
Асгат сум	4	65.5	4	65.5	-	-
Баруун - Урт сум	2	260.0	1	100	1	160
Дарьганга сум	3	80.0	2	50	1	30
Онгон сум	6	161.3	6	161.3	-	-
Наран сум	3	60.8	3	60.8	-	-
Түвшинширээ сум	2	19.0	2	19	-	-
Түмэнцогт сум	9	801.5	7	540.9	2	260.6
Сүхбаатар сум	2	71.6	1	8.4	1	63.2

<sup>5</sup> Урьчилсан саналын жагсаалтыг аймаг, нийслэлийн дэргэдэх иргэний танхимаар нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг 10 дугаар сарын 31 ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулна.

<sup>6</sup> хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

Уулбаян сум	3	80.9	3	80.9	-	-
Халзан сум	3	164.0	2	34	1	130
Эрдэнэцагаан сум	2	29.0	2	29	-	-
Нийт дүн	39	1793.6	33	1149.8	6	643.8

Судалгаанаас үзэхэд сумдын ИТХ-аар шинээр хийгдэх барилга угсралты ажил, их засвар болон тоног төхөөрөмж суурилуулахад 1793.6 сая төгрөг батлагдснаас 33 ТАХ-ний зураг төсөв хийгдээгүй ажилд 1149.8 сая төгрөг баталсан байна.

### 1.5 Дарьганга, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Баяндэлгэр сум ИНХ-аар дэмжигдээгүй 7 төсөл арга хэмжээг 62460.0 мянган төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний жагсаалтийг ИТХ-аар нэг бүрчлэн хэлэлцэж баталжээ. Аймгийн ОНХС-гаар 15 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр хэлэлцэн баталсанаас зураг төсөвгүй 2 төсөл арга хэмжээнд 204619.4 мянган төгрөгийг баталж Сангийн сайдын 2012 оны 244 тоот тушаалын хавсралт “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3<sup>7</sup> дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал аймгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, тохижуулах зардалд 155.0 сая, Үйлдвэрчний эвлэлийн байрыг засварлахад 49.6 сая төгрөг баталсан байна. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг сумын ИТХ-д оруулж батлуулсан боловч ИТХ-ын төлөөлөгчид төсөл, арга хэмжээ тус бүрээр хэлэлцээгүй, ЗДТГ-ын нэгтгэн оруулсан жагсаалтыг баримтлах, аймгийн ОНХС-гаас хуваарилагдах орлогын шилжүүлэгт тулгуурлан хөрөнгийг баталж байна. Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалын хавсралт “орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5.10<sup>8</sup> дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна. Зарим сум БИНХ-аар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг ЗДТГ нэгдсэн жагсаалтанд оруулж ИТХ-аар батлуулсан нь “Төсвийн тухай” хуулийн 60.3.6<sup>9</sup> заалтыг зөрчсөн байна.

Тухайлбал: **Дарьганга сумын** ОНХС-аас засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал буюу Соёлын төвийн цуурай дарах ажилд 2205.0 мянга, хүүхдийн цэцэрлэгийг хашаажуулахад 5400.0 мянга, цагдаагийн машинд сэлбэг худалдан авахад 1000.0 мянга, **Сүхбаатар сум** өвсний фонд үүсгэхэд 10350.0 мянга, наадмын талбайн засварт 7900.0 мянга, **Эрдэнэцагаан** сум өндөр хурдны интернэтийн тоног төхөөрөмж суурилуулахад 24000.0 мянга, **Баяндэлгэр** сум 90 жилийн ойн бичлэг хийлгэхэд 3000.0 мянга нийт 62460.0 мянган төгрөгийн 7 төсөл арга хэмжээг иргэдийн санал аваагүй байхад төсөвт тусгаж, гүйцэтгэсэн байна.

<sup>7</sup> хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх;

<sup>8</sup> Сум дүүргийн ИТХ нь сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг төсөл тус бүрээр хэлэлцэн төсвийн төсөлд тусган “орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын сум/дүүргийн ИТХ-ын хуралдааны тогтоол /загвар маяг/-ын 3 дугаар хавсралтын дагуу батална.”

<sup>9</sup> Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж баталагдаагүй төсөл арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.

Дэд зорилт-2 : Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, тогтоомжид заасан журмын бүрдүүлж, зарцуулсан эсэх

2

## БҮЛЭГ 2

Аймгийн ОНХС-гийн орлогыг хууль тогтоомжид заасан нэр төрлөөр бүрдүүлж байгаа боловч зарим сумд ОНХС-гийн орлогын шилжүүлгээс өөр эх үүсвэрээр орлого бүрдүүлээгүй, БУА болон бараа ажил үйлчилгээг гүйцэтгэлээр хүлээн аваагүй байна.

### 2.1. Аймгийн ОНХС-гийн орлогыг хууль тогтоомжид заасан нэр төрлөөр бүрдүүлж байгаа боловч зарим сумд ОНХС-гийн эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр идэвхи санаачлагатай ажиллаагүй байна.

Орлогын эх үүсвэрийг гүйцэтгэлээр авч үзвэл ОНХС-гаас 4012.4 сая, орон нутгийн төсвөөс 1401.1 сая, суурь орлого зарлагын зөрүүгээс 233.6 сая, хандив тусламжаар /Цайрт минерал ХХК/ 1560.0 сая нийт 7207.1 сая төгрөг төвлөрч 1436.8 сая төгрөг буюу 16.6 %-иар төлөвлөсөн орлого тасарчээ. ОНХС-гийн эх үүсвэр дутуу санхүүжигдсэн нь ОНХС-гаас 843.9 сая төгрөгийн орлогын шилжүүлэг дутуу хуваарилагдсан, орон нутгийн татварын орлого тасарсан, зарим уул уурхайн компаниуд тухайн жил үйл ажиллагаа явуулаагүйгээс 288.0 сая төгрөгийн хандивын орлого төвлөрөөгүй зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Харин зарим сумдын ОНХС-ийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давсан, татварын болон орлогын эх үүсвэрийг боломжит хэмжээндээ дайчилсан зэрэг тодорхой үр дүнгүүд гарсан байна. Үүнд:

- Түмэнцогт сум аймгийн ОНХС-ийн орлогын шилжүүлэг 71300.0 мянга, газрын дуудлага худалдаанаас 737938.2 мянга, жишиг хорооллын хашаанаас 3800.0 мянга, өмнөх оны аудитаар тогтоосон актын эргэн төлөлт 70000.0 мянга нийт 886838.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.
- Халзан сум ОНХС-гийн орлогын шилжүүлэгээр 155842.2 мянга, орон нутгийн төсвийн орлогын давалтаас 14410.0 мянга, уул уурхайн Эл Эм Цахиурт овоо ХХК-аас хандив тусламжаар 80000.0 мянга нийт 259252.2 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.
- Баруун-Урт сум орлогын шилжүүлэгээр 247100.0 мянга, орон нутгийн татварын орлогоос 40000.0 мянга, хашааны орлогоос 9000.0 мянга, аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх 6-р багийн тохижилтийн ажлын төлөвлөсөн хөрөнгөнөөс 50000.0 мянган төгрөгийн эрх шилжүүлж нийт 346100.0 мянга төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.
- Уулбаян сум орлогын шилжүүлэгээр 115229.7 мянга, орон нутгийн төсвийн орлогын давалтаас 19500.0 мянган төгрөг хуваарилан баталсан байна.
- Мөнххаан сум орлогын шилжүүлэгээр 130498.7 мянган, Бүрэнцогтын уурхайгаас 15000.0 нийт 145498.7 мянган төгрөг төвлөрүүлжээ.

Дээрх 4 сум нь уул уурхайн хандив тусламж, газрын дуудлага худалдаа болон орон нутгийн төсвийн орлогын давалтаас ОНХС-д хөрөнгө төвлөрүүлж ИТХ-аар төсвийг тодотгуулан төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Сүхбаатар, Асгат, Наран, Онгон, Түвшинширээ, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Дарьганга сумдын ОНХС-д хандив тусламж, орон нутгийн төсвийн орлогын давалт болон бусад эх үүсвэрээс хөрөнгө төвлөрөөгүй аймгийн ОНХС-гийн орлогын шилжүүлэгээр төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

## **2.2. ОНХС-гийн хөрөнгийн 63.4 хувийг өмнөх оны ажлын дутуу гүйцэтгэл, он дамжин хэрэгжиж буй ТАХ-нд зарцуулсан байна.**

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд шинээр 15 төсөл арга хэмжээнд 1203.8 сая төгрөг баталж гүйцэтгэлээр 1163.6 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 40.2 сая төгрөг дутуу санхүүжигдсэн байна. Шинээр хийгдсэн 565.6 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер шалгаруулж, 83.6 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээг холбогдох байгууллагад эрх шилжүүлж, 625.8 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээг шууд гэрээ байгуулсан байна. Мөн өвөлжилтийн бэлтгэл ажил хангахад 100.0 сая төгрөгийг “Дөрвөлж” ОНӨҮГ-т, зүүн бүсийн хурд баяр наадмын зардалд 85.0 сая төгрөг зарцуулсан байна. Тайлант онд өмнөх оноос шилжиж ирсэн 15 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 4605.3 сая төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 4300.7 сая төгрөг олгож, 304.6 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. Шууд гэрээгээр гүйцэтгэсэн төсөл арга хэмжээг авч үзвэл 10 дугаар цэцэрлэгийн байр худалдан авахад 320000.0 мянга, 60 авто машины зогсоол барихад 74430.3 мянга, үйлдвэрчний эвлэлийн байрны засварт 49619.4 мянга, 10 цэцэрлэгийн барилгын их засвар хийхэд 181804.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажил шууд гэрээ байгуулсан нь Засгийн газрын 2013 оны 68<sup>10</sup> дугаар тогтоолыг зөрчсөн байна. Сумдын үр дүнг авч үзвэл:

Түмэнцогт сум тодотголоор өмнөх оны өр барагдуулахад 68879.4 мянга, шинээр 13 төсөл арга хэмжээнд 961529.5 мянган төгрөг батлагдсан байна. Шинээр хэрэгжүүлэх 506721.5 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтаар, 190840.5 мянган төгрөгийн 4 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар, 48967.5 мянган төгрөгийн 6 арга хэмжээг шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна. Цэвэр усны 900 м шугам, ус өргөх цамхагийн шинэчлэл, уурын зуухны яндангийн шинэчлэлийн 366721.5 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Их модун” ХХК гүйцэтгүүлсэн боловч ГХБХБГазарт хүсэлт гаргаж гэрээ байгуулаагүйгээс ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналт хийгдээгүй байна. Мөн 80000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй музейн барилгын өргөтгөл, засвар, 50202.8 мянган төгрөгийн өртөгтэй хүүхдийн тоглоомын талбайн ажлын гүйцэтгэл дутуу байхад хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон нь Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн” журмын 3.3<sup>11</sup> дах заалтыг зөрчжээ. Эмнэлэгийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийг хуулийн дагуу зохион байгуулалгүй, шууд гэрээ байгуулан

<sup>10</sup> Худалдан авах ажиллагааны журмыг сонгох босго үнэ

<sup>11</sup> Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг ..... тухай барилгын ажлын батлагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр тулган шалгаж баталгаажуулна.

тусгай зөвшөөрөлгүй, мэргэжлийн бус хувь хүнтэй 10000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж “хаш чулуун эмчилгээний” тоног төхөөрөмж худалдан авсан байна.

Эрдэнэцагаан сум 9 төсөл арга хэмжээг 105800.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ. ЕБС-ийн дээврийн засварын ажлыг харьцуулалтын аргаар, 8 төсөл арга хэмжээнд шууд гэрээ байгуулжээ. Худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулж байгаа хэдий ч ЕБС-ийн уурийн зуухны тогоог худалдан авахдаа шууд гэрээ байгуулж Засгийн газрын 2013 оны 68<sup>12</sup> дугаар тогтоол, тендерийн хуулийг баримтлаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Баяндэлгэр сум батлагдсан хөрөнгийг өмнөх онд гүйцэтгэсэн ажлын дутуу санхүүжилтэнд олгохоор тооцож, шинээр 1 ажил хийж гүйцэтгэсэн байна. Сумын 90 жилийн ойн баримт кино хийлгэхэд 3000.0 мянган төгрөг зарцуулагдсан нь төсвийг зориулалт бус батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж “Төсвийн тухай” хуулийн 60.3.3<sup>13</sup> дах заалт, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 7.4<sup>14</sup> дах заалтыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

Сүхбаатар сум шинээр 7 төсөл арга хэмжээнд 72000.0 мянган төгрөг, өмнөх онд үүссэн өр төлбөрт 43400.0 мянган төгрөг зарцуулсан байна. Шинээр хийгдсэн 63000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд нээлттэй тендер сонгон шалгаруулалт явуулж тайланд онд 17000.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна. Мөн 6 төсөл арга хэмжээнд шууд гэрээ байгуулж 87800.0 мянган төгрөг зарцуулжээ.

Мөнххаан сум шинээр ажил хийхээр төлөвлөөгүй, өмнөх оны ажлын дутуу санхүүжилтэнд 130498.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Асгат сум** ОНХС-гийн орлогын шилжүүлэгээр 122765.5 мянган төгрөг хуваарилагдаж оны эхний үлдэгдэл 1044.0 мянга нийт 123809.5 мянган төгрөг төвлөрснөөс өмнөх оны ажлын үлдэгдэл санхүүжилтэнд 47495.1 мянган төгрөг зарцуулж шинээр 7 төсөл арга хэмжээнд 76314.4 мянган төгрөг зарцуулжээ. Төлөвлөсөн 7 ТАХ-нд шууд гэрээ байгуулсанаас “усны машин худалдан авах” барааг тендерийн хуулийн дагуу сонгон шалгаруулаагүй байна.

Мөн сумын төвийн авто замын зураг төсөв хийлгэхэд АР СИ ЭС СИ ХХК-тай 2000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч гүйцэтгэгч компанид 4000.0 мянган төгрөг шилжүүлж гэрээний дүнгээс 2000.0 төгрөг илүү шилжүүлсэнд төлбөрийн акт тогтоолоо.

**Халзан сум** батлагдсан төсвөөс өмнөх оны ажлын дутуу санхүүжилтэнд 89700.0 мянга төгрөг олгож шинээр 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Сумын төвд 280000.0 мянган төгрөгийн өртөгтэй төвлөрсөн халаалтын шугамд холбоход сумын ОНХС-гаас 130000.0 мянга, аймгийн төсвөөс 150000.0 төгрөг батлагдснаас 63600.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Дээрх шугамын ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр “ТӨТҮ” констракшн ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна. Мөн сумын баяр наадмын талбайг засварлах 20000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг хувь хүнтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн боловч ХХОАТ-т 2000.0 мянган төгрөг суутган

<sup>12</sup>

<sup>13</sup> Үндэсний их баяр наадмаас бусад баяр наадам, ойн арга хэмжээ..... зардал

<sup>14</sup> Сумын ОНХС-гийн хөрөнгөөр төсвийн тухай хуулийн 58.4-т заасан чиг үүргийг хэрэгжүүлж болно

тооцохгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосонд Татварын ерөнхий хуулийн 18.1.1<sup>15</sup>, 1.3<sup>16</sup>, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулын 23.1<sup>17</sup> заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоолоо.

**Баруун-Урт сум** өмнөх оны дутуу санхүүжилтэнд 100575.2 мянган төгрөг, шинээр 19 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна. Гэр хорооллын хашаа гудамжийг цэгцлэх ажилд сумын ОНХС-гаас 100000.0 мянга, аймгийн ОНХС-гаас 50000.0 мянган төгрөг баталжээ. Уг ажлыг гүйцэтгэхтэй холбоотой харьцуулалтын аргаар 50000.0 мянган төгрөгийн бараанд тендер сонгон шалгаруулалт явуулж, 100000.0 мянган төгрөгийн ажилд тендер зохион байгуулалгүй аж ахуйн тооцоон дээр сумын ажилгүй иргэдийг хамруулан гүйцэтгэсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7.2<sup>18</sup> заалтыг зөрчжээ. Дээрх ажлын хүрээнд 1, 4, 5 багуудын айл өрхийн хашааг шинэчлэн, цэгцэлж иргэдээс хашааны төлбөр болох 30843.5 мянган төгрөгийг бэлнээр авч төрийн сангийн харилцах дансаар дамжуулалгүй захиран зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны 276 тушаалын “Төсвийн байгууллагын мөнгөн кассны ажиллагаан”-ны журмын 2.6<sup>19</sup> дах заалтыг зөрчжээ. Хөрөнгийн зарцуулалтыг тулган баталгаажуулахад хувь хүнээс бараа худалдан авч ХХОАТ-ыг суутган тооцоогүй 1800,0 мянга, анхан шатны баримтаар нотлогдоогүй 2350.0 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулсанд төлбөрийн акт тогтоолоо.

Мөн орон сууцны дундах талбайг тохижуулах 160000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд нээлттэй тендер сонгон шалгаруулалт явуулсан боловч гүйцэтгэгчээр тендерийн нөхцөлд тохирохгүй шинээр үүсгэн байгуулагдсан, барилга угсралтын ажил явуулах тусгай зөвшөөрөлгүй “Уудамхангай наран” ХХК-г сонгон шалгаруулж ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7.1.1<sup>20</sup>, Нээлттэй тендер сонгон шалгаруулалтын журмыг<sup>21</sup> зөрчсөн байна. Мөн Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалын 7.4 дэх заалтыг зөрчиж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 2100.0 мянга, СӨХ үйл ажиллагааг дэмжихэд 5300.0 мянга, нийтийн тээврийн үйлчилгээг дэмжихэд 10000.0 мянга, багуудын өдөрлөг зохион байгуулахад 8944.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Эдгээр зөрчил дутагдалд албан шаардлага хүргүүлээ.

**Түвшинширээ сум** өмнөх оны ажлын дутуу санхүүжилтэнд 108859.2 мянган төгрөг олгож, шинээр төв талбайн ажилд 10000.0 мянга, ЕБС-ийн дээврийн засварт 9500.0 мянга, квош трактор худалдан авахад 19600.0 мянган төгрөг зарцуулсан байна. Квош худалдан авахад нээлттэй тендер сонгон шалгаруулалт явуулж гүйцэтгэгчээр Оточ оргил ХХК-г сонгон шалгаруулсан байна. Төв талбайн газар шорооны ажилд ажилласан хүмүүст 10000.0 мянган төгрөгийн ажлын хөлс

<sup>15</sup> татвар ногдох зүйл, татвараа үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;

<sup>16</sup> анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам болон нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлж, санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргах;

<sup>17</sup> Энэ хуулийн 17-19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна.

<sup>18</sup> Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө

<sup>19</sup> Үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг бэлнээх хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шуул захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан нярав төрийн сан дах бүртгэлийн дансанд тушаана.

<sup>20</sup> Нээлттэй тендер шалгаруулалтын журам

<sup>21</sup> Тендерг оролцогч ТООЗ-ны 1.1-д заасан ажлыг гүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна

олгож 1000.0 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүйд төлбөрийн акт тогтоолоо.

Аймаг, сумын ОНХС-аас өмнөх оны ажлын дутуу гүйцэтгэлийг санхүүжүүлсэн байдлыг хүснэгтээр харуулбал.

Мян. төг

Сумын нэр	2014 онд үүссэн өглөг он дамжин хийгдэх ажил	2015 онд санхүүжилтээс өмнөх оны дутуу санхүүжилт олгосон байдал	2014 оны үлдэгдэл өглөг	2015 онд үүссэн өглөг	нийт өглөг
1 Асгат сум	66,516.10	47,495.10	19,021.00	11,989.80	31,010.80
2 Баруун - Урт сум	100,575.20	100,575.20	-	-	
3 Баяндэлгэр сум	226,062.90	140,157.90	85,905.00	-	85,905.00
4 Дарьганга сум	4,550.00	2,613.60	1,936.40	70,063.50	71,999.90
5 Мөнххаан сум	131,000.00	131,000.00	-	85,000.00	85,000.00
6 Онгон сум	47,881.10	42,681.10	5,200.00	66,776.60	71,976.60
7 Наран сум	91,965.70	58,082.00	33,883.70	21,116.30	55,000.00
8 Түвшинширээ сум	98,955.20	98,955.20	-	45,900.00	45,900.00
9 Түмэнцогт сум	68,879.40	68,879.40	-	-	
10 Сүхбаатар сум	43,489.70	43,489.70	-	75,149.60	75,149.60
11 Уулбаян сум	77,030.00	67,030.00	10,000.00	53,000.00	63,000.00
12 Халзан сум	102,000.00	89,700.00	12,300.00	69,900.00	82,200.00
13 Эрдэнэцагаан сум	-	-	-	21,000.00	21,000.00
Сумын дүн	1,058,905.30	890,659.20	168,246.10	519,895.80	688,141.90
Аймгийн ОНХС	4,605,340.40	4,300,740.80	304,599.60	40,190.10	344,789.70
<b>Аймгийн нийт дүн</b>	<b>5,664,245.70</b>	<b>5,191,400.00</b>	<b>472,845.70</b>	<b>560,085.90</b>	<b>1,032,931.60</b>

Аймгийн хэмжээнд нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг худалдан авах ажиллагааны ил тод нээлттэй байх зарчмыг баримтлан 2015 онд ОНХС-аар хийгдэх ажлын төлөвлөгөө, тендерийн урилгыг өдөр тутмын сонин, [www.procurement.mn](http://www.procurement.mn), орон нутгийн BBS, SB телевиз болон бусад мэдээллийн хэрэгслээр нээлттэй явуулсан байна. Сумдууд өндөр төсөвт өртөгтэй тендер сонгон шалгаруулалтыг явуулахдаа аймгийн худалдан авах ажиллагаанд хүсэлт гарган хамтран зохион байгуулах нь зүйтэй гэж үзэж байна. Тухайбал: Шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлын тендер сонгон шалгаруулах үнэлгээний хороонд мэргэжлийн хүн ордоггүй тендер сонгон шалгаруулалтын эрхийн гэрчилгээтэй сумын орлогч дарга, ЗДТГ-ын дарга, төрийн сангийн мэргэжилтэн зэрэг хүмүүс томилогдож байгаа нь тухай ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулахад хүндрэл гарч байна.



### 2.3. Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг комисс ажлын гүйцэтгэлээр хүлээн аваагүйгээс 43157.5 мянган төгрөгийн ажил дутуу хийгдсэн байна

Аймгийн болон сумын засаг даргын захирамжаар томилогдсон комисс бараа, ажил, үйлчилгээг акт үйлдэж хүлээн авсан боловч тухайн ажлын гүйцэтгэл болон тенхикийн тодорхойлолтыг баримталж гүйцэтгэл нэг бүрээр тулган баталгаажуулж хүлээн авдаггүй, комиссын эрх үүргийг хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал: Түмэнцогт суманд гүйцэтгэсэн хүүхдийн талбайн ажил, соёлын төвийн засварын өргөтгөлийн ажлыг хүлээн авахдаа 14729.3 мянган төгрөгийн гүйцэтгэл дутуу хийгдсэн байхад хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон байна. Аудитын явцад эдгээр зөрчил дутагдалыг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүллээ.



а. Түмэнцогт сумын гаднах ажил дутуу хийгдсэн барилга

б. Хүүхдийн тоглоомын талбай тоглоом дутуу суурилуулсан байдал

Халзан суманд хийгдсэн наадмын талбайн засварын ажилд зарцуулсан материалын тооцоог тулган баталгаажуулахад тус ажилд 4500.0 мянган төгрөгийн ажил дутуу хийгдсэн.

Уулбаян сумын 50000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй явган хүний замыг гүйцэтгэгч Манал овоот ХХК-ний гаргасан ажлын төсвөөр тулган баталгаажуулахад төсөвт тусгагдсан хэмжээнээс 1500м<sup>2</sup> явган хүний зам буюу 21428.0 мянган төгрөгийн ажил хийгдээгүй ажлыг гэрээний хугацаанд хүлээлгэн өгөөгүй нь Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоол “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах дүрэм”-ын 4.12<sup>22</sup>, 4.13<sup>23</sup> заалтыг зөрчсөнд хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

<sup>22</sup> Комисс нь дараахь эрх, үүрэгтэй

<sup>23</sup> Захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, гүйцэтгэгч нь дараахь эрх үүрэгтэй



*В. Манал овоот ХХК-ийн хийж гүйцэтгэсэн явган хүний зам*

Мөн Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр эрх шилжин хийгдсэн 10000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 6 дугаар бичил цэцэрлэгт хүрээлэнгийн ажил чанаргүй хийгдсэн бөгөөд 2500.0 мянган төгрөгийн ажил дутуу хийгдсэн байхад БОАЖГ-ын дарга комисс томилж хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон нь Сангийн сайдын 2012 оны 290 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн” журмын 3.3<sup>24</sup> дах заалтыг зөрчжээ. Мөн ямар байгууллага эзэмшиж, ашиглалтанд хяналт тавих нь тодорхойгүйгээс данс бүртгэлд тусгаагүй байна.

Түвшинширээ сум 55000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ковш тракторыг худалдан авч, биетээр ашиглаж байгаа боловч санхүүжилтийг бүрэн шийдвэрлээгүй гэсэн шалтгаанаар бүртгэл тайланд тусгаагүй нь Сангийн сайдын 2012 оны 290 тушаал “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн” журмын 5.1<sup>25</sup> дэх заалтыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ. байна.

Сумын ОНХС-аар хийгдсэн БУА, ТАХ-г хүлээн авах комисс хуульд заасан эрх үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн, мэргэжлийн боловсон хүчин дутмагаас ажлын гүйцэтгэл бүрэн дуусаагүй байхад хүлээн авдаг зэрэг нийтлэг зөрчил дутагдал гарч байна. Иймд орон нутагт ОНХС-аар хийгдсэн ТАХ-г хүлээн авахад баримтлах журмыг боловсруулах, төсвийн гүйцэтгэлийг хянадаг сургалтанд хамруулах, өндөр төсөвт өртөгтэй ажлуудын Тендер сонгон шалгаруулалтыг ХАА-ны албатай хамтран зохион байгуулах, техник хяналтын зардлыг тусгуулж ГХБХБГ-тай гэрээ байгуулан захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байх шаардлагатай байна.

<sup>24</sup> Захиалагч байгууллага төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг ..... тухай барилгын ажлын баглагдсан зураг төсөл, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг үндэслэн ажил нэг бүрээр тулган шалгаж баталгаажуулна.

<sup>25</sup> Төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажил нь төрийн болон орон нутгийн өмчид заавал бүртгэх бөгөөд .... худалдан авсан тоног төхөөрөмжийг хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр байгууллагын тайлан балансад бүртгэнэ.

3

## БҮЛЭГ 3

**Дэд зорилт-3:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх

**ОНХС-ийн хэрэгжилтийг байгууллагын ил тодын самбар, зарим вэб сайтуудад байршуулсан хэдий ч захиалагчийн хяналт, ИТХ-ын болон санхүүгийн хяналт дотоод аудитын албын явцын хяналт хангалтгүй хэрэгжиж байна.**

### 3.1. ОНХС-гийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд ИТХ-аас холбогдох заавар, журмын дагуу хяналт хийгдээгүй байна.

Аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албыг засаг даргын захирамжаар 2014 онд санхүүгийн хяналтын 4 байцаагчтайгаар байгуулж 2016 онд дотоод аудитын нэг орон тоог нэмж ажиллуулсан байна. 2015 онд санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ОНХС-д төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэхээр тусгагдсан боловч тодорхой шалтгааны улмаас хойшлогдож 2016 оны төлөвлөгөөнд Эрдэнэцагаан, Сүхбаатар, Баяндэлгэр, Түвшинширээ сумдуудын төсвийн байгууллагууд болон тусгай сандуудад төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэхээр тусгагдсан байна. Аймгийн ИТХТ-ын даргын баталсан төлөвлөгөөний дагуу ОНХС-гийн зарцуултанд хяналт шалгалт хийхээр 2 ажлын хэсэг 12 суманд ажилласан боловч шалгалтын тайланд ОНХС-гийн зарцуулалттай холбогдон гарсан зөрчлийн талаар болон шийдвэрлэсэн үр дүнгийн талаар тодорхойгүй зүйлүүд тусгагдаагүй байна. Баруун-Урт сумын ИТХ-ын дарга, төлөөлөгч 10 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 150000.0 мянган төгрөгийн өртөгтэй хашаа гудамж цэгцлэх ажилд хяналт тавих, ажлын явцтай танилцсан байна. Сумдуудын ИТХ-ын дэргэд хяналтын хороо байгуулсан боловч ажлын төлөвлөгөө батлуулаагүй, хяналт хийсэн ажлын тайлан гаргаж ИТХ-аар хэлэлцүүлээгүй нь хяналтыг хангалтгүй хэрэгжүүлснийг харуулж байна.

### 3.2 Аймгийн бүтээн байгуулалтын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг иргэдэд хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлсэн байна.

Аймгийн болон сумдын ОНХС-гийн төлөвлөгөө гүйцэтгэлийг [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) сайтад байршуулсан эсэхийг тулган баталгаажуулахад Асгат, Дарьганга, Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт сумдууд мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.3<sup>26</sup>, 6.8.2<sup>27</sup> дах заалтыг зөрчсөн байна. Эдгээр зөрчил дутагдалд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн аудитаар албан шаардлага хүргүүлээд байна.

<sup>26</sup> тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

<sup>27</sup> худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендер оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендер шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;

Аймгийн ЗДТГ-ын ХМОНХ мэргэжилтэн нь албан ёсны [www.sukhbaatar.mn](http://www.sukhbaatar.mn) цахим хуудас, [www.facebook.com/sukhbaatarprovince](https://www.facebook.com/sukhbaatarprovince) фэйсбүүк хуудсаар мэдээллийг тогтмол хүргэж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг BBS телевизийн Today news, SB телевизийн SB NEWS мэдээллийн хөтөлбөрүүдээр орон нутгийн бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээлсэн байна.

“Сүхбаатарын өнгө” сонин 4 нүүрээр 1000 хувь хэвлэгддэг бөгөөд 2015 онд 7 удаа хэвлэгдсэн байна. Нэг дугаарт дунджаар 20, нийт 140 гаруй мэдээ мэдээлэл, ярилцлага, сурвалжлагыг олон нийтэд түгээсэн байна. Тус сонин хөдөөгийн 12 сум, Баруун-Урт сумын багуудад тараагддаг.

Аймгийн Засаг дарга 2015 онд “Сүхбаатарын өнгө”, “Зууны мэдээ”, “Эх орны манаа” зэрэг сонин, “Нутгийн удирдлага”, “VIP Expert”, “Хот&City”, “Жавхлант шарга” зэрэг сэтгүүл, [www.vip76.mn](http://www.vip76.mn), [www.news.mn](http://www.news.mn), [www.ikon.mn](http://www.ikon.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn) зэрэг сайт, “Монцамэ” агентлаг, МҮОНТ, Эх орон, ETV, Eagle зэрэг телевизэд ярилцлага өгч төрийн зүгээс хэрэгжүүлж буй бодлого, хийж буй ажил, бүтээн байгуулалтын талаар нээлттэй мэдээлсэн байна.

Аймгийн нийгэм - эдийн засаг, хөрөнгө оруулалт - бүтээн байгуулалтын өсөлт, статистик үзүүлэлт бүхий 100 хуудастай үзүүлэн /presentation/-г ойролцоогоор 24 удаа улс, бүс, аймаг, сумын хурал чуулган, уулзалт семинарт танилцуулжээ.

2015 онд Эрдэнэцагаан, Онгон, Наран, Баяндэлгэр, Дарьганга сумдад байрлах хилийн 17 засталаар иргэдтэй уулзаж, аймгийн нийгэм, эдийн засгийн байдлын талаар мэдээлэл хийсэн байна.

Баруун-Урт сумын засаг дарга 2015 онд орон нутгийн BBS телевизийн шууд ярилцлаганд оролцож сумын ОНХС-гийн хөрөнгөөр болон бусад эх үүсвэрээр хийгдсэн бүтээн байгуулалтын ажил, цаашид хийгдэх ажлуудын талаар иргэдтэй ярилцаж хэлэлцүүлэг явуулсан байна. Мөн [baruun-urt.mn](http://baruun-urt.mn), [ith.baruun-urt.mn](http://ith.baruun-urt.mn) сайтууд, байгууллагын мэдээллийн ил тод байдлын самбарт тухай бүр байршуулснаас гадна Сүхбаатарын өнгө сонины 2015 оны 9 дугаарт 2015 онд хийгдсэн бүтээн байгуулалтын ажлын талаар бүрэн хэмжээний ярилцлага өгсөн байна.

Эрдэнэцагаан сум орон нутгийн Талын долгион телевизтэй гэрээ байгуулж сард 2 удаа орон нутгийн бүтээн байгуулалт болон бусад мэдээ мэдээллийг ард иргэддээ хүргэж байна.

Бусад сумын хэмжээнд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ажлын төлөвлөгөөг багийн ИНХ болон ил тодын мэдээллийн самбарт байршуулах хэлбэрээр хүргэж байгаа нь иргэдэд хүртээмж хүрч чаддаггүй байна.

### **3.3 Өмнөх оны аудитаар өгсөн акт 86.2%, албан шаардлага 96.9%, зөвлөмж 81.8%-тай хэрэгжсэн байна.**

2015 оны ОНХС-гийн аудитаар Онгон суманд 2500.0 мянга, Түвшинширээ суманд 12000.0 мянга, Түмэнцогт суманд 70000.0 мянга, аймгийн СТСХ-т 9700.0 мянга нийт 94200.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож 81200.0 мянган төгрөгийн актыг барагдуулж 86.2%-ийн биелэлттэй гарсан байна. Түвшинширээ сумын 12000.0 мянган төгрөгийн актыг барагдуулаагүй нь жишиг хорооллын

хашааг иргэд худалдан авсан боловч хашааны үнийг хугацаанд нь төлөөгүй нь нөлөөлсөн байна. Мөн зөрчил арилгуулах 2487400.0 мянган төгрөгийн 18 албан шаардлага хүргүүлж 2457500.0 мянган төгрөгийн албан шаардлага хэрэгжиж 98.8%-тай биелсэн байна. Эрдэнэцагаан сумын засаг даргад 29900.0 мянган төгрөгийн дутуу хийгдсэн ажлыг гүйцэтгэгчээр хийлгэж дуусгах албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй байгаа тул Төрийн аудитын тухай хуулийн 28.2.2<sup>28</sup> заасны дагуу хариуцлага тооцох бичгийг аймгийн засаг даргад хүргүүллээ. Аудитаар сумдын ИТХ-д 3, засаг дарга, түүний ажлын албанд 7, худалдан авах ажиллагааны албанд 1 нийт 11 зөвлөмж өгснөөс ИТХ-д өгсөн “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ, гүйцэтгэл, санхүүжилтийн зарцуулалтанд сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо хяналт шалгалт хийж, үнэлгээ өгч хэвших”, “ОНХС-ийн төсвийг зураг, төсөв, ТЭЗҮ нь боловсрогдсон ТАХ-г төсөл тус бүрээр хэлэлцэн, хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлах” 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн ОНХС-ийн төлөвлөлтийг хууль тогтоомжийн дагуу боловсруулсан боловч ихэнх сумд ОНХС-г төлөвлөөгүй, орлогын шилжүүлгийг хуульд заасан харьцаагаар хуваарилаагүй, ИНХ-аар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн байна.
2. Зарим сумд ОНХС-гийн орлогын шилжүүлгээс өөр эх үүсвэрээр орлого бүрдүүлээгүй, ТАХ-г хүлээн авах комисс бараа ажил үйлчилгээг гүйцэтгэлээр хүлээн аваагүй, захиалагчийн хяналтыг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлээгүй байна.
3. ОНХС-ийн хэрэгжилтийг байгууллагын ил тодын самбар, зарим вэб сайтуудад байршуулсан хэдий ч захиалагчийн хяналт, ИТХ-ын болон санхүүгийн хяналт дотоод аудитын албын явцын хяналт хангалтгүй, өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 88.9%-тай хэрэгжсэн байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Төрийн байгууллагын эрх захирагч нарт

**Зөвлөмж:**

**Сумын Засаг дарга, багийн дарга нарт**

1. ОНХС-г хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль тогтоол, заавар журмыг орон нутгийн болон малчин иргэдэд ухуулан танилцуулж сурталчилах ажлыг зохион байгуулах.
2. ТАХ-ний явцын хяналтыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, БУА болон бараа ажил үйлчилгээг хүлээн авах комисст тухай ажлын онцлогоос хамааруулан мэргэжлийн хүн томилон ажиллуулах
3. ОНХС-гийн хөрөнгийг Сангийн сайдын 2012 оны 244 тушаалын дагуу төлөвлөж, орлогын эх үүсвэрийг Төсвийн тухай хуульд заасан төрөл бус бүрээр бүрдүүлэхэд идэвхи санаачлагатай ажиллах

**Сумын ИТХ-ын дарга нарт**

1. ИТХ-ын дэргэдэх хяналтын хороог байгуулж, хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргуулан баталж ажлын тайланг ИТХ-аар хэлэлцүүлж үнэлэлт дүгнэлт өгч байх
2. ОНХС-ийн хөрөнгийг батлахдаа ЗДТГ-аас нэгтгэн гаргасан жагсаалт тус бүрээр хэлэлцэж ИНХ-аар дэмжигдээгүй болон зураг төсөв батлагдаагүй ТАХ-нд хөрөнгө батлахгүй байх.

**Аймгийн ЗДТГ-т**

1. Тухайн онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг гаргаж Иргэний танхимаар нээлттэй хэлэлцүүлэг явуулж ИТХ-аар батлуулах

## Байгууллагаас ирсэн санал:



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА  
22000 Баруун-Урт, Сүхбаатар аймаг  
Утас, факс: 70512121, 70518232

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2016.04.29 № 6/476  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тайлбар, санал хүргүүлэх тухай

2015 оны орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтын байдалд хийсэн аудитын тайлантай танилцаад дараахь тайлбар, саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтанд хийгдсэн аудитын тайланд тусгагдсан зөрчлүүдийн ихэнх нь сумдын орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалттай холбоотой зөрчил байна. Аймгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын зүгээс сумдын удирдлагууд холбогдох мэргэжилтнүүдэд сургалт, цаг үеийн ажлын семинар хийж хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах, төсвийн гүйцэтгэлийг хэрхэн зохион байгуулах талаар зөвлөгөө өгөн ажиллаж байгаа хэдий ч зөрчил дутагдлууд давтагдан гарсаар байна. Өдөр тутмын ажлын зохион байгуулалт, хяналт, шийдвэр гаргах үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн хүрээнд сумдын удирдлагуудад байдаг учир тухай бүр хянах боломж бага байдаг. Гарч байгаа зөрчил дутагдлуудын шалтгаан байдлыг судалж үзвэл ажил хариуцсан хүмүүсийн мэдлэг чадвар муу, хариуцлагагүй байдалтай холбоотой зүйлүүд ч байна, мөн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах шаардлагатай зүйлүүд ч бас байна. Иймд гарч буй зөрчлийн шалтгаан байдлыг нарийн судалж холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахад хөндлөнгийн аудитын байгууллагын оролцоо дүгнэлт зайлшгүй хэрэгтэй тул та бүхэнтэй хамтран ажиллах шаардлага ч бий болж байна.

2. Орон нутгийн хөгжлийн сангийн 2014 оны батлагдсан хөрөнгө 2,9 тэрбум төгрөгөөр дутуу ирсэн, 2015 оны батлагдсан хөрөнгийг оны эхэнд тодотгон хорогдуулсан. Энэ тодотголын дараа бүх аймаг, сумд нэг талаас хууль тогтоомжинд нийцүүлж, нөгөө талаас гүйцэтгэгчидтэй зөвшилцөх, гэрээнд өөрчлөлт оруулах, төлбөр тооцоогоо хойшлуулах зэрэг байдлаар ажил төрлөө зохицуулан тодотгол хийсэн. Гэтэл тодотгож баталсан мөнгө ондоо ирээгүй, 844,0 сая төгрөгөөр дутуу санхүүжигдсэн. Үүнээс шалтгаалан төр гэрээний үүргээ биелүүлээгүйгээс өрийн сүлжээнд орсноор олон аж ахуйн нэгжүүд ялангуяа орон нутгийн жижиг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа зогсоход хүрч байна. Цаашилбал, банкны зээл, нийлүүлэгч байгууллагуудын өр гэх мэтээр хөдлөх боломжгүй болж бизнесийн үйл ажиллагаа нь хумигдах, ингэснээр татвар төлөлт багасаж, төсвийн орлого буурах гээд хор уршиг бий болж байгаа нь аудитын явцад тогтоогдож байгаа учир үүнийг эрх бүхий байгууллагуудад уламжлах нь зүйтэй юм.

3. Хууль тогтоомжид зааснаар ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээнд ард иргэдээс санал авах үйл ажиллагаа нь өмнөх оны 3 дугаар улиралд хийгддэг. Гэтэл энэ хугацаанаас хойш төсөв батлагдах, хэрэгжих хүртлэх хугацаанд

000108

цаг үеийн шинжтэй, тулгамдсан, зайлшгүй шийдвэрлэвэл зохих олон асуудлууд гардаг. Үүнийг ард иргэдээс санал аваагүй гээд орхигдуулж болохгүй, тиймээс хууль тогтоомж зөрчигддөг гэх мэтчилэн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зарим бэрхшээлүүд гардаг. Ер нь ард иргэдийн саналыг авах нь зайлшгүй чухал хэдий ч нийт аймгийн хэмжээний ирээдүйд ач холбогдол нь гарах бодлогыг дэмжихээсээ илүүтэй өөрсдийн өнөөдрийн явцуу эрх ашгаа бодсон хөрөнгө оруулалтыг дэмжих явдал гардаг. Үүнийг бас хууль тогтоомжийн хүрээнд зохицуулах шаардлага гарч байгаа юм.

4. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ирсэн орлогын шилжүүлгийг хуульд заасан харьцаагаар хуваарилаагүй гэсэн дүгнэлтийн хувьд нэг талаас нийт гүйцэтгэлээрээ л хуульд заасан харьцаагаар хуваарилагдсан байх боломжтой бөгөөд төсвийн жилийн явцад бол үүссэн нөхцөл, цаг үеийн байдалтайгаа холбоотойгоор нэн шаардлагатай арга хэмжээнд эхэлж хуваарилах замаар үйл ажиллагаагаа зохицуулдаг. Тайлант онд нийт гүйцэтгэлээрээ хуульд заасан харьцаагаар хуваарилагдаагүй шалтгаан нь орлогын шилжүүлэг дутуу ирсэн, орон нутгийн төсвийн орлогоос хуваарилагдах хөрөнгө мөн дутуу хуваарилагдсантай холбоотой болно.

5. Төсвийн тухай шинэ хууль хэрэгжиж орон нутгийн хөгжлийн санг бий болгож, энэхүү сангийн хөрөнгөөр орон нутгийн хөрөнгө оруулалт, бүтээн байуулалтын нь ажлыг хийж байгаа орон нутгийн зүгээс хууль тогтоомжид заагдсан эрх үүргээ хэрэгжүүлэх, ард иргэдийн оролцоотойгоор бодит хэрэгцээ шаардлагад нийцсэн үйл ажиллагааг явуулах, тулгамдсан асуудлууд дээр цаг хугацаа алдахгүй байх зэрэг олон боломжуудыг бүрдүүлсэн, маш чухал ач холбогдолтой зүйл болсон бөгөөд энэ нь амьдрал дээр ч харагдаж байгаа юм. Гэхдээ энэ нь шинэ тутам хэрэгжиж байгаа, сумдад ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн мэдлэг чадварын дутагдалтай байдал, хууль тогтоомж, заавар журмуудыг боловсронгуй болгох шаардлага зэрэгтэй холбоотойгоор зарим зөрчлүүд гарч байгааг үгүйсгэхгүй байна.

Цаашид тайланд тусгагдсан алдаа дутагдлыг арилгах, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай саналыг хүргүүлэх, ОНХС-ын үр өгөөжийг дээшлүүлэх зэрэг чиглэлээр та бүхэнтэй хамтран ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Д.ХОСБАЯР

## Шалгагдагч байгууллагаас ирсэн саналд өгөх тайлбар

1. Төсвийн тухай хуулийн 63.1-д ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-г олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна гэж заасан. Мөн Сангийн сайдын 2014 оны 43 тушаалаар батлагдсан зааврын 7.2-д аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний чиглэлийг заасан байдаг. Иймд ОНХС-гаар хэрэгжих төсөл арга хэмжээг иргэдээс ирсэн саналын дагуу төлөвлөж захиран зарцуулах ёстой юм. Харин аймгийн бодлого



төлөвлөлттэй уяалдуулан иргэдээс санал авах эрх хэмжээ нь төсвийн захирагчид байгаа болно.

2. Төсвийн тухай хуулийн 59.2-т ОНХНС-гаас олгосон шилжүүлэгийн 60-аас доошгүй хувийг сумын ОНХС-д хуваарилна гэж заасны дагуу 2015 онд ОНХНС-гаас хуваарилсан 4012.4 сая төгрөгийн 60% буюу 2407.4 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилах ёстой байсан. Харин санхүүжилт дутуу ирсэн гэсэн шалтгаанаар сумдад олгох орлогын шилжүүлгийг дутуу олгож болохгүй юм.
3. Бусад зорилтуудын хүрээнд саналын зөрүүтэй асуудал гараагүй.

**ТАЙЛАН БИЧСЭН:**

**АХЛАХ ШИНЖЭЭЧ**

**С.АРИУНБАЯР**

**АУДИТОР**

**О.БАРЧИДГҮНСЭН**

**ХЯНАЖ БАТАЛГААЖУУЛСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

**М.НАРАНТУЯА**

**АУДИТЫН МЕНЕЖЕР**

**Г. ДАВАА**